



ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ

Дугаар 05/2012

Улаанбаатар хот
2012 он



ГАРЧИГ

Агуулга	Хуудасны дугаар
1. Мал аж ахуйн салбар	2
2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ	3
3. Газар тариалангийн салбар	6
4. Аж үйлдвэрийн салбар	7
5. Цаг агаар	12

Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээг ашиглав.

1. МАЛ АЖ АХУЙН САЛБАР

Улсын хэмжээнд 2011 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 15.7 сая хээлтэгч малын 12.9 сая хээлтэгч буюу 81.9 хувь нь 2012 оны эхний 5 сарын байдлаар төллөсөн байна. Эм хонины 87.2 хувь, эм ямааны 83.3 хувь, үнээний 57.8 хувь, гүүний 50.6 хувь, ингэний 42.3 хувь нь төлөжээ.

Гарсан төлийн 98.7 хувь буюу 12711.6 мян.толгой төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1149.9 мянга буюу 9.9 хувиар их байна.

Унага бойжилт 97.8 хувь, тугал 98.3 хувь, ботго 98.5 хувь, хурга 98.9 хувь, ишиг 98.5 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.2-1.4 пунктээр өсчээ.

Зүй бусаар 2012 оны эхний 5 сард улсын хэмжээгээр 238.4 мян.толгой мал хорогдож, өмнөх оны мөн үеийнхээс 198.7 мян.толгой буюу 45.5 хувиар буурав. Зүй бусаар хорогдсон малыг төрлөөр авч үзвэл адуу 12.4 мянга, үхэр 22.2 мянга, тэмээ 469, хонь 94.4 мянга, ямаа 108.8 мянга байна. Нийт хорогдлын 39.6 хувийг хонь, 45.7 хувийг ямаа эзэлж байна.

Мал төллөлт

(жил бүрийн эхний 5 сарын байдлаар)

Эх малын төрөл	Төллөсөн хээлтэгч, мян.толгой			Төллөлтийн хувь		
	2010 ¹⁻⁵	2011 ¹⁻⁵	2012 ¹⁻⁵	2010 ¹⁻⁵	2011 ¹⁻⁵	2012 ¹⁻⁵
Бүгд	9195.7	11836.8	12851.6	48.4	76.2	81.8
Гүү	173.8	255.7	324.6	26.8	43.1	50.6
Үнээ	355.8	419.9	558.4	34.8	46.6	57.8
Ингэ	26.6	34.2	40.7	29.6	37.7	42.3
Эм хонь	4966.5	5786.8	6206.2	57.3	81.5	87.2
Эм ямаа	3673.0	5340.1	5721.7	42.9	78.0	83.3

Төл бойжилт

(жил бүрийн эхний 5 сарын байдлаар)

Төлийн төрөл	Бойжуулсан төл, мян.толгой			Бойжилтын хувь		
	2010 ¹⁻⁵	2011 ¹⁻⁵	2012 ¹⁻⁵	2010 ¹⁻⁵	2011 ¹⁻⁵	2012 ¹⁻⁵
Бүгд	6709.5	11561.7	12711.6	72.8	97.4	98.7
Унага	153.6	249.3	316.2	88.4	97.5	97.8
Тугал	314.1	411.9	547.4	88.3	98.1	98.3
Ботго	24.9	33.5	40.0	93.8	97.9	98.5
Хурга	3671.8	5654.7	6153.0	73.7	97.5	98.9
Ишиг	2545.1	5212.2	5654.9	69.1	97.3	98.5

Зүй бусаар хорогдсон том мал
(жил бүрийн эхний 5 сарын байдлаар)

Малын төрөл	Хорогдсон том мал, мян.тол			Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь		
	2010 ¹⁻⁵	2011 ¹⁻⁵	2012 ¹⁻⁵	2010 ¹⁻⁵	2011 ¹⁻⁵	2012 ¹⁻⁵
Бүгд	8821.0	437.2	238.4	20.0	1.3	0.7
Тэмээ	7.6	0.8	0.5	2.7	0.3	0.2
Адуу	298.0	16.9	12.4	13.4	0.9	0.6
Үхэр	501.8	35.7	22.2	19.3	1.6	0.9
Хонь	3636.6	185.0	94.4	18.9	1.3	0.6
Ямаа	4377.0	198.7	108.8	22.3	1.4	0.7

2. ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ

Хонины нэхийн зах зээлийн дундаж үнэ, төг

Аймаг, нийслэл	Хонины /ноостой/ нэхий, ширхэг		Аймаг, нийслэл	Хонины /ноостой/ нэхий, ширхэг	
	2011.V	2012.V		2011.V	2012.V
Баруун бүс			Төвийн бүс		
Баян-Өлгий	8000	4500	Говьсүмбэр	8000	9000
Говь-Алтай	10500	7500	Дархан-Уул	6000	8000
Завхан	10000	10000	Дорноговь	-	5000
Увс	8000	8000	Дундговь	11000	7000
Ховд	5000	6000	Сэлэнгэ	5000	6500
Хангайн бүс			Төв	9000	9000
Архангай	11000	8000	Зүүн бүс		
Баянхонгор	10500	8000	Дорнод	7500	7000
Булган	5500	8000	Сүхбаатар	5000	5500
Орхон	9500	7500	Хэнтий	10000	7000
Өвөрхангай	10000	5000	Улаанбаатар		
Хөвсгөл	10500	8000	Улаанбаатар	7000	6000

Үхрийн ширний зах зээлийн дундаж үнэ, төг

Аймаг, нийслэл	Үхрийн шир, ширхэг			
	2 м-ээс доош урттай		2 м-ээс дээш урттай	
	2011.V	2012.V	2011.V	2012.V
Баруун бүс				
Баян-Өлгий	10000	20000	10000	-
Говь-Алтай	-	16000	10000	25000
Завхан	12500	20700	14500	25000
Увс	-	20000	-	23000
Ховд	12000	-	-	15000
Хангайн бүс				
Архангай	18000	25000	26000	35000
Баянхонгор	16000	-	-	30000
Булган	11500	23500	20000	33500
Орхон	15000	20000	23000	30000
Өвөрхангай	-	25000	17000	32000
Хөвсгөл	18000	25000	22000	30000
Төвийн бүс				
Говьсүмбэр	10000	-	25000	25000
Дархан-Уул	10000	-	23000	20000
Дундговь	-	12700	-	20700
Сэлэнгэ	14000	20000	25000	30000
Төв	18500	28000	26500	32000
Зүүн бүс				
Дорнод	17500	20000	19500	25000
Сүхбаатар	12500	22500	23500	30000
Хэнтий	15000	26000	-	-
Улаанбаатар				
Улаанбаатар	18500	25000	30000	40000

Адууны ширний зах зээлийн дундаж үнэ, төг

Аймаг, нийслэл	Адууны шир, ширхэг		Аймаг, нийслэл	Адууны шир, ширхэг	
	2011.V	2012.V		2011.V	2012.V
Баруун бүс			Төвийн бүс		
Баян-Өлгий	20000	20000	Говьсүмбэр	25000	25000
Говь-Алтай	15000	-	Дархан-Уул	24000	25000
Завхан	20000	30000	Дундговь	20500	23000
Увс	-	-	Өмнөговь	18000	-
Ховд	-	15000	Сэлэнгэ	25000	20000
Хангайн бүс			Төв		
Архангай	26000	20000	Төв	26500	28000
Баянхонгор	-	25000	Зүүн бүс		
Булган	20000	25000	Дорнод	20500	20000
Орхон	22000	23000	Сүхбаатар	24000	22500
Өвөрхангай	20000	25000	Хэнтий	25000	27000
Хөвсгөл	25000	20000	Улаанбаатар		
			Улаанбаатар	28000	25000

Ямааны ноолуурын зах зээлийн дундаж үнэ, төг

Аймаг, нийслэл	Ямааны ноолуур, кг			
	Цагаан		Бор	
	2011.V	2012.V	2011.V	2012.V
Баруун бүс				
Баян-Өлгий	56000	43000	56000	43000
Говь-Алтай	55000	42000	55000	42000
Завхан	56500	43500	56500	43500
Увс	54000	43000	-	43000
Ховд	53000	41000	-	-
Хангайн бүс				
Архангай	55000	45000	55000	45000
Баянхонгор	55000	43000	55000	42500
Булган	-	-	42500	40500
Орхон	50000	40000	50000	40000
Өвөрхангай	55000	44000	55000	44000
Хөвсгөл	56000	46000	58000	48000
Төвийн бүс				
Говьсүмбэр	47500	40000	-	-
Дархан-Уул	50000	42000	50000	42000


Дорноговь	50000	41000	50000	41000
Дундговь	-	42300	51000	-
Өмнөговь	52000	-	52000	-
Сэлэнгэ	45000	35000	45000	35000
Төв	52500	45000	52500	45000
Зүүн бүс				
Дорнод	49500	35000	-	35000
Сүхбаатар	47500	37500	40000	35000
Хэнтий	40000	-	-	-
Улаанбаатар				
Улаанбаатар	58000	41000	45000	41000

3. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАР

Улсын хэмжээнд 2012 оны 6 дугаар сарын 1-ний байдлаар 284.9 мян.га талбайд тариалалт хийснээс үр тариа 257.3 мян. га-д, төмс 12.6 мян.га-д, хүнсний ногоо 4.6 мян.га-д, тэжээлийн ургамал 4.5 мян.га-д, техникийн ургамал 5.9 мян.га-д тариалсан байна.

Нийт тариалсан талбай өмнөх оны мөн үеийнхээс 4.5 мян.га буюу 1.6 хувиар бага байгаагийн дотор үр тарианых 12.4 мян.га буюу 4.6 хувиар буурч, харин төмснийх 1.7 мян.га буюу 15.5 хувь, хүнсний ногооных 640.9 га буюу 16.4 хувь, тэжээлийн ургамлынх 1.7 мян.га буюу 58.7 хувиар нэмэгдсэн байна.

Тариалсан талбай, жил бүрийн 6 дугаар сарын 1-ний байдлаар, га



4. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2012 оны эхний 5 сард 834.0 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 69.9 тэрбум төг буюу 9.1 хувиар өслөө.

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл оны үнээр 2012 оны эхний 5 сард 2120.0 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 320.0 тэрбум төг буюу 17.8 хувиар өссөн.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2012 оны эхний 5 сард оны үнээр 2322.8 тэрбум төг болж, үүний 1539.2 тэрбум төг буюу 66.3 хувийг гадаад зах зээлд борлуулжээ.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн, салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая төг

Аж үйлдвэрийн салбар	2011 ^V	2012 ^V	2011 ^{I-V}	2012 ^{I-V}	$\frac{2012^{I-V}}{2011^{I-V}}$ (%)
Аж үйлдвэрлийн нийт бүтээгдэхүүн, 2005 оны зэрэгцүүлэх үнээр	179807.4	187971.5	764126.8	834033.0	109.1
Боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн	66069.7	57474.9	218044.0	231748.7	106.3
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	25252.7	26684.3	116623.4	127016.2	108.9
Тамхи үйлдвэрлэл	2622.2	2722.8	8019.2	7885.4	98.3
Нэхмэлийн үйлдвэрлэл	17107.5	5942.4	39616.7	27937.5	70.5
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	703.1	750.5	3102.6	2576.6	83.0
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	1097.6	1654.3	1206.3	2022.6	167.7
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	157.2	183.4	825.6	988.7	119.8
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	235.0	385.2	915.8	1756.4	191.8
Тавилга үйлдвэрлэл, бусад	105.6	943.0	431.2	1176.0	272.7

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн, салбараар, оны үнээр, сая төг

Аж үйлдвэрийн салбар	2011 ^V	2012 ^V	2011 ^{I-V}	2012 ^{I-V}	Үүнээс: гадаадад
Аж үйлдвэр, бүгд	429995.4	539661.4	1890740.7	2322759.8	1539170.6

Боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн	122285.7	190174.9	409350.9	714919.0	278901.3
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	48462.1	64482.2	221230.0	281499.4	2570.7
Тамхи үйлдвэрлэл	3800.0	3833.9	15900.0	16826.8	-
Нэхмэлийн үйлдвэрлэл	26991.7	9795.2	61363.6	48965.7	26232.0
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	1040.0	484.9	4170.3	3533.0	-
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	622.2	533.5	828.9	881.9	274.7
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	698.8	1214.2	3207.2	4320.8	-
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1007.8	1264.0	4124.6	5228.5	-
Тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	94.0	169.4	504.1	794.8	1.9





Зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

<i>Бүтээгдэхүүн</i>	<i>хэм. нэгж</i>	<i>2011^V</i>	<i>2012^V</i>	<i>2011^{I-V}</i>	<i>2012^{I-V}</i>	<i>$\frac{2012^{I-V}}{2011^{I-V}} \%$</i>
Хивс	мян.м2	67.1	74.2	324.2	387.0	119.4
Сүлжмэл эдлэл	мян.ш	59.4	64.9	263.7	258.0	97.8
Самнасан ноолуур	тн	250.5	18.0	378.7	101.5	26.8
Эсгий	мян.м	25.6	10.8	65.5	107.6	164.3
Тэмээний ноосон хөнжил	мян.м	0.2	0.3	10.5	2.5	23.8
Эсгий гутал	мян.хос	3.1	2.5	15.7	12.3	78.1
Нэхий дээл	ш	1280	444	6595	2452	37.2
Савхин гутал, ботинк	мян.хос	0.4	1.0	2.1	5.3	251.4
Барилгын модон хаалга, цонх	м2	599.7	964.6	2718.8	2253.0	82.9
Барилгын шалны банз	м3	-	-	148.0	531.5	359.1
Зүсмэл материал	м3	890.3	148.3	2628.0	2101.1	80.0
Дэвтэр	мян.ш	870.0	1038.8	2658.8	3515.6	132.2
Ариун цэврийн цаас	мян.ш	178.7	364.2	812.7	1953.9	240.4
Бичгийн цаас	тн	6.8	13.5	106.7	64.7	60.6
Сонин	сая.х.д.х	3.3	5.0	15.6	20.7	132.7
Ном	сая.х.д.х	4.2	4.6	17.1	21.2	124.3

Шахмал түлш	тн	-	-	770.4	4129.5	536.0
Гоо сайхны тос	мян.ш	63.4	87.1	244.4	326.0	133.4
Вакуум цонх, хаалга	м2	1085.1	648.8	2216.7	1831.7	82.6
Цемент	мян.тн	52.9	45.9	142.2	102.7	72.2
Бетон зуурмаг	м3	7802.5	1607.7	15463.8	5308.3	34.3

Хүнсний салбарын зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	хэм. нэгж	2011 ^V	2012 ^V	2011 ^{I-V}	2012 ^{I-V}	$\frac{2012^{I-V}}{2011^{I-V}}\%$
Үхрийн мах	тн	0.9	5.4	186.8	457.1	244.7
Хонины мах	тн	-	1.3	233.9	415.0	177.4
Адууны мах	тн	0.8	-	56.7	16.8	29.8
Ямааны мах	тн	0.0	0.5	59.7	300.0	502.5
Гахайн мах	тн	1.2	1.9	8.3	8.1	97.6
Өлөн гэдэс	мян.гогцоо	35.3	77.4	347.8	499.3	143.6
Хиамны зүйл	тн	174.6	172.8	820.5	784.8	95.6
Боловсруулсан шингэн сүү	мян.л	1740.9	2349.1	9202.1	11272.1	122.5
Тараг	мян.л	875.8	923.3	3524.1	3392.3	96.3
Цөцгий, цөцгийн тос	тн	47.7	147.9	366.4	683.7	186.6
Аарц, бяслаг	тн	2.4	38.5	24.7	123.8	501.2
Дээд гурил	тн	2409.0	272.5	9408.8	4251.3	45.2
Нэгдүгээр гурил	тн	4953.7	3801.7	30770.7	19699.9	64.0
Хоёрдугаар гурил	тн	1359.4	2177.4	5263.1	6774.1	128.7
Нарийн боов	тн	1080.6	1113.8	4954.3	5402.7	109.1
Бялуу	тн	94.9	81.4	210.1	321.2	152.9
Чихэр	тн	4.8	10.6	38.9	40.4	103.9
Талх	тн	1739.3	2117.4	8508.4	10044.1	118.0
Гоймон	тн	231.1	4.9	756.3	448.4	59.3
Спирт	мян.л	288.1	262.6	1679.5	1892.6	112.7
Архи	мян.л	2061.3	2000.9	10819.2	10914.8	100.9
Дарс	мян.л	14.2	7.0	51.1	39.6	77.5
Шар айраг	мян.л	5098.4	5687.8	22602.2	26574.9	117.6
Цэвэр ус	мян.л	2939.6	4004.5	9194.2	13614.8	148.1
Амтат ус, ундаа	мян.л	6898.5	7776.4	24056.0	28518.0	118.5
Жүүс	мян.л	4955.5	5593.9	19364.5	25094.3	129.6



Экспортын гол нэрийн бараа

Бараа	хэм.нэгж	2011 ^{1-V}	2012 ^{1-V}	$\frac{2012^{1-V}}{2011^{1-V}} \%$
Үхрийн хөлдүү мах	т	1618.8	-	-
Адууны мах	т	91.8	250.1	272.6
Малын дайвар бүтээгдэхүүн	т	261.5	942.3	360.3
Шеврет	сая дм ²	163.1	77.2	47.3
Шевро	сая дм ²	89.0	28.5	32.1
Адууны шир	мян.ш	128.2	69.5	54.2
Хонины самнаагүй ноос	т	4430.7	1199.7	27.1
Бохир ноолуур	т	1823.8	1444.3	79.2
Самнасан ноолуур	т	90.8	124.7	137.3
Свитер, пуловер, джемпер, жилет болон сүлжмэл гадуур цамц	мян.ш	37.5	5.8	15.8

Импортын гол нэрийн бараа

Бараа	хэм.нэгж	2011 ^{1-V}	2012 ^{1-V}	$\frac{2012^{1-V}}{2011^{1-V}} \%$
Өндөг	мян.ш	26737.0	32120.6	120.1
Төмс	т	3393.0	2042.4	60.2
Сонгино, сармис	т	6487.1	4697.3	72.4
Алим, лийр	т	3115.2	1193.9	38.3
Ногоон цай	т	1063.1	775.6	73.0
Цагаан будаа	т	3583.5	5536.3	154.4
Шар будаа	т	817.4	618.5	75.7
Гурил	мян.т	33.0	28.5	86.5
Ургамлын тос	т	1753.0	2717.5	155.0
Элсэн чихэр	т	15579.8	13843.9	88.9
Хатуу чихэр	т	2321.2	2100.1	90.5
Согтууруулах биш ундаа	мян.л	5959.9	5680.6	95.6
Согтууруулах ундаа	мян.л	6008.1	8871.7	147.7
Үүнээс: Шар айраг	мян.л	5499.5	8464.7	153.9
Янжуур	сая.ш	685.8	854.0	124.5
Азотын бордоо	т	13862.5	30031.7	216.6



5.ЦАГ АГААР

2012 оны 7 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээ **

УУР АМЬСГАЛЫН ТОЙМ

Манай оронд зуны саруудаас хамгийн дулаан нь долдугаар сар бөгөөд агаарын температурын сарын дундаж нь Өмнөговь, Дорноговийн нутаг, Ховд, Говь-Алтай, Баянхонгорын өмнөд хэсгээр 21-26, Хөвсгөл, Архангайн ихэнх нутаг, Алтай, Баянхонгор, Өвөрхангайн хойд, Завханы зүүн, Баян-Өлгийн өмнөд хэсгээр 10-14, бусад нутгаар 15-20 градус дулаан байдаг. Гэвч цаг агаарын нөхцөл жил бүр харилцан адилгүй. Тухайлбал: 1996 онд баруун, төвийн нутгаар, 1999-2002, 2004-2005, 2007, 2008 онд ихэнх нутгаар олон жилийн дунджаас 2-5 градусаар дулаан, өдрийн үнэмлэхүй их температур Орхон-Сэлэнгийн бэлчир, говийн нутгаар 36-43, бусад нутгаар 33-38 градус хүрч халж байсан бол 1976 онд баруун ба говийн нутаг, төвийн нутгийн баруун хэсгээр, 1978 онд говь ба зүүн зүгийн нутгаар олон жилийн дунджаас нилээд хүйтэрч, шөнийн үнэмлэхүй бага температур уулархаг нутгаар 3-8 градус хүйтэн, бусад нутгаар 2 градус дулаанаас 3 градус хүйтэн байжээ. Цочир хүйтрэл сарын аль ч үед ажиглагддаг. Энэ сард олон жилийн дунджаар Булган, Сэлэнгийн ихэнх нутаг, Хөвсгөл, Архангайн зүүн хэсэг, Өвөрхангай, Хэнтий, Дорнодын хойд хэсгээр 80-115, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Өмнөговь, Дорноговийн ихэнх нутаг, Увс, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд хэсгээр 10-38, бусад нутгаар 40-79 мм бороо ордог боловч 1993, 1994 онд ихэнх нутгаар, 1996-1998, 2003 онд нутгийн баруун хагаст олон жилийн дунджаас 1-3 дахин их бороо орсон бол 1999-2002, 2007 онд олон жилийн дунджаас харьцангуй бага бороо орж байжээ. Дуу цахилгаан жил бүр 4-8, зарим жил 10-14 удаа ажиглагддаг. Салхи 15 м/с-ээс хүчтэй болох тохиолдол жил бүр 1-3, зарим жилд 5-6 удаа ажиглагддаг бөгөөд салхины хамгийн их хурд 1991 онд говийн нутгийн зүүн хэсгээр түр зуур 28-36 м/с хүрч онц хүчтэй шороон шуурга шуурсан байна.


ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Баруун зүгийн нутаг. Агаарын температурын сарын дундаж нь уулархаг нутгаар 12-17, Алтайн өвөр говиор 22-27, бусад нутгаар 18-23 градус дулаан буюу Баян-Өлгийн хойд, Увсын баруун хэсгээр олон жилийн дунджийн орчим, бусад нутгаар олон жилийн дунджаас 1.5-2.0 градусаар дулаан байна ([3 дугаар зураг](#)).

Нэг ба гуравдугаар арав хоногийн дунд үе, хоёрдугаар арав хоногийн сүүлчээр сэрүүсч уулархаг нутгаар шөнөдөө 5-10, өдөртөө 16-21 градус дулаан, Их нууруудын хотгор, Алтайн өвөр говиор шөнөдөө 15-20, өдөртөө 25-30 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 11-16, өдөртөө 18-23 градус дулаан байна. Бусад хугацаанд уулархаг нутгаар шөнөдөө 8-13, өдөртөө 20-25 градус дулаан, Их нууруудын хотгор, Олон нууруудын хөндий, Алтайн өвөр говиор шөнөдөө 18-23, өдөртөө 28-33 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 14-19, өдөртөө 26-31

градус дулаан байх ба ялангуяа хоёрдугаар арав хоногийн эхний хагаст Их нууруудын хотгор, Олон нууруудын хөндий, Алтайн өвөр говиор өдөртөө 34-39, бусад нутгаар 29-34 градус хүрч халах төлөвтэй.

Энэ сард орох хур борооны нийт хэмжээ нь Ховд, Говь-Алтайн өмнөд, Увсын зүүн, Завханы хойд болон зүүн, Баянхонгорын хойд хэсгээр олон жилийн дунджийн орчим, бусад нутгаар олон жилийн дунджаас бага буюу зөвхөн Завханы хойд хэсгээр дунджаас ахиу байна ([4 дүгээр зураг](#)).



Нэгдүгээр арав хоногийн эхний хагаст болон хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар бороо орно. Харин нэгдүгээр арав хоногийн эцэс, хоёрдугаар арав хоногийн эхээр нутгийн хойд хэсгээр, гуравдугаар арав хоногийн сүүлчээр зарим нутгаар түр зуурын бороо орно. Дуу цахилгаантай. Борооны өмнө салхи зарим нутгаар түр зуур 16-18 м/с хүрч ширүүснэ.

Төвийн нутаг. Агаарын температурын сарын дундаж нь нутгийн баруун хэсгээр 12-17, бусад нутгаар 17-22 градус дулаан буюу Хөвсгөл, Булган, Сэлэнгийн хойд хэсгээр олон жилийн дунджийн орчим, бусад нутгаар олон жилийн дунджаас 1.5-2.0 градусаар дулаан байх төлөвтэй ([3 дугаар зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн дунд үе, хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн сүүлийн хагаст сэрүүсч Хангай, Хөвсгөлийн уулархаг нутгаар шөнөдөө 5-10, өдөртөө 14-19 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 11-16, өдөртөө 19-24 градус байна. Бусад хугацаанд Орхон, Сэлэнгийн сав нутгаар шөнөдөө 18-23, өдөртөө 28-33 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 15-20, өдөртөө 26-31 градус дулаан байх ба хоёрдугаар арав хоногийн дунд үеэр Орхон, Сэлэнгэ, Хараа, Туул голын сав нутгаар 32-37 градус, бусад нутгаар 29-34 градус хүрч халах төлөвтэй.

Энэ сард Хөвсгөлийн зүүн, Булганы хойд, Сэлэнгийн баруун хойд, Өвөрхангайн өмнөд хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар олон жилийн дунджийн орчим бороо орох



төлөвтэй ([4 дүгээр зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн эхэн болон дунд үе, хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн сүүлийн хагаст ихэнх нутгаар бороо орох төлөвтэй. Харин нэгдүгээр арав хоногийн эцэс, хоёрдугаар арав хоногийн эхний хагаст зарим газраар гол төлөв түр зуурын бороо орно. Дуу цахилгаантай. Борооны өмнө салхи зарим газраар түр зуур хүчтэй ширүүсч болзошгүй.

Зүүн зүгийн нутаг. Агаарын температурын сарын дундаж нь ихэнх нутгаар 18-23 градус дулаан буюу олон жилийн дунджаас 1.5-2.0 градусаар дулаан байна ([3 дугаар зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн дунд үе болон гуравдугаар арав хоногийн сүүлчээр сэрүүсч нутгийн хойд хэсгээр шөнөдөө 7-12, өдөртөө 16-21 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 11-16, өдөртөө 20-25 градус дулаан байна. Сарын бусад хугацаанд ихэнх нутгаар шөнөдөө 13-18, өдөртөө 25-30 градус дулаан байх бөгөөд хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхээр зарим нутгаар шөнөдөө 15-20, өдөртөө 30-35 градус хүрч халах төлөвтэй.

Энэ сард орох борооны нийт хэмжээ нь Хэнтийн өмнөд, Сүхбаатарын баруун хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар олон жилийн дунджийн орчим байна ([4 дүгээр зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн дунд үе болон сүүлч, гуравдугаар арав хоногийн сүүлчээр ихэнх нутгаар бороо орно. Харин нэгдүгээр арав хоногийн эхэн ба хоёрдугаар арав хоногийн ихэнх хугацаанд болон гуравдугаар арав хоногийн дунд үеэр зарим нутгаар түр зуурын бороо орно. Дуу цахилгаантай. Борооны өмнө зарим газраар салхи түр зуур 16-18 м/с хүртэл ширүүсч болзошгүй.

Говийн нутаг. Агаарын температурын сарын дундаж нь Дундговийн нутаг, Дорноговийн хойд, Өмнөговийн баруун хэсгээр 17-22, бусад нутгаар 22-27 градус дулаан буюу ихэнх нутгаар олон жилийн дунджаас 1.5-2.5 градусаар дулаан байна ([3 дугаар зураг](#)).

Нэг ба гуравдугаар арав хоногийн дунд үе болон хоёрдугаар арав хоногийн сүүлчээр сэрүүвтэр нутгийн хойд хэсгээр шөнөдөө 10-15, өдөртөө 19-24 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 12-17, өдөртөө 23-28 градус дулаан байна. Бусад хугацаанд ихэнх нутгаар шөнөдөө 15-20, өдөртөө 27-32 градус дулаан байх ба ялангуяа хоёрдугаар арав хоногийн дунд үе болон гуравдугаар арав хоногийн эхээр зарим нутгаар 33-38 градус хүрч хална.

Энэ сард Өмнөговийн зүүн өмнөд, Дорноговийн баруун өмнөд, Дундговийн баруун хойд хэсгээр олон жилийн дунджийн орчим, бусад нутгаар олон жилийн дунджаас бага бороо орох төлөвтэй ([4 дүгээр зураг](#)).

Нэгдүгээр арав хоногийн дунд үе болон сүүлч, хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар бороо орох төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн эхэн,



хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн сүүлчээр зарим газраар түр зуурын бороо орно. Дуу цахилгаантай. Борооны өмнө зарим газраар салхи түр зуур 18-20 м/с хүртэл ширүүсч болзошгүй.

*** - Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газар, Ус, цаг уурын хүрээлэн*